

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
2023 ОНД ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|--|------|--|-----------------|--|---------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ | | | | | | |
| 1 | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 20 | <p>2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгах саналыг хэлтэс, албадаас аван, төлөвлөгөөг боловсруулж Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хамруулах 2023 оны сургалтын төлөвлөгөөнд нийт 25 арга хэмжээ тусгагдсан ба үүнээс 22 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 4 дүгээр улирлын байдлаар нийт 22 сургалт болон үйл ажиллагаа зохион байгуулагдсан үүнээс байгууллага дотооддоо зохион байгуулсан сургалт 8, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 12 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан ба давхардсан тоогоор 1238 албан хаагч хамрагдсан байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Алсын хараа-2050” сертификаттай сургалтад 6 албан хаагч хамрагдав.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад хөгжлийн бодлогын баримт бичгийн талаар ойлголтыг өгөх, бодлогын баримт бичиг боловсруулах, арга аргачлалд сургах, чадавхжуулах зорилготойгоор “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй”</p> | |

| | | | | | |
|--|--------|--------------------------|---|--|--|
| | | | | сэдэвт сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 5 болон 7-ны өдрүүдэд нийт 16 цагийн сургалтад 16 албан хаагч хамрагдсанаас 11 алба хаагч сертификат гардан авсан. | |
| | Үүнээс | Ажлын байран дах сургалт | <p>1.1.1. Баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөх ур чадварыг сайжруулах сургалт</p> | <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-аас 2023 оны 03 сарын 06-ны өдөр хамтран зохион байгуулсан "ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо" сэдэвт сургалтад 4 албан хаагч, Байгууллага дотооддоо "ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоо" сэдвээр нийтдээ 9 удаагийн сургалтыг зохион байгуулж ажлын хэсэг болон Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ажилтан, албанн хаагчид хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагын төрийн албанд анх томилогдсон албан хаагчид болон шинэ томилогдсон архив, бичиг хэргийн ажилтнуудад баримт бичгийн стандарт, журмын дагуу бүрдүүлэх мэдлэг олгох "Баримт бичгийн стандарт баримт, бичгийг зохион бүрдүүлэх" сэдэвт сургалтад 2023 оны 03 дугаар сарын 23 болон 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд нийт 15 ажилтан, албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>"Монгол хэлний тухай" хуулийн 24.2 дах заалт "2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хөтөлнө" гэсэн заалтыг хэрэгжүүлэх бэлтгэх ажлыг хангах хүрээнд монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 14-ний өдрүүдэд Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 50 албан хаагчдад нийт 14 цагийн хичээл заахаар төлөвлөснөөс 2 цагийн танхим, 6 цагийн цахим хичээлийг зохион байгуулсан.</p> | |
| | | | <p>1.1.2. Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа</p> | <p>Нийслэлийн Засаг даргын Хүний нөөцийн хөгжлийн төв болон Австрали Tale Queensland хамтран байгууллагын баг хамт олны хооронд үр дүнтэй харилцааг бий болгох, зөрчилдөөн болон асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг үлгэрлэн манлайлах ур чадвар, туршлагаа харилцан солилцох боломжийг төрийн албан хаагчдад олгох зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 28-</p> | |

| | | | | | |
|--|--|--|--|---|--|
| | | | <p>хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх</p> | <p>ны өдөр зохион байгуулсан “Ажлын байрны үр дүнтэй харилцааг удирдан манлайлах нь”, “Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэн ашиглах нь” сэдэвт сургалтад 4 албан хаагч хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хар тамхитай тэмцэх газраас хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор уршиг үр дагаврын талаар мэдлэг олгох, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр Нийслэлийн Засаг захиргааны 2-р байрны /Хангарди ордон/ 14 дүгээр давхрын Б танхим болон Төр захиргааны цогцолбор байрны Хурлын танхимд зохион байгуулж нийт албан хаагчид хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газраас хамтран “Газар хөдлөлтийн гамшиг”, “Гал түймрийн аюул” сэдэвт сургалтыг гал түймэр, газар хөдлөлтийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэл, дадлага олгох зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 06-ний өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын сургалтын танхимд байгууллагын нийт 45 ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулж газар хөдлөлт, түүний хор уршиг, газар хөдлөлтийн үед яаралтай авах арга хэмжээнүүд, гал түймрээс урьдчилан сэргийлэх, “Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж”-ийн талаарх мэдлэг, мэдээллийг олгосон. Мөн газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээ, галын хор болон гал унтраах багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, гал гарсан үед галын хорыг хэрхэн ажиллуулах талаар ажилтан, албан хаагчдад дадлагын хичээл орсон.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс байгууллагын албан хаагчид өөрсдийн манлайллын ур чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, манлайллын арга барилаа сайжруулах аргачлалыг зааж өгөх зорилготой 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт 8 цагийн сургалтад байр хариуцсан менежерүүд болон утгах үйлчилгээний ажилтнууд нийт 22 албан хаагч хамрагдав.</p> | |
|--|--|--|--|---|--|

| | | | | | |
|--|--|--|--|---|--|
| | | | | <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан төрийн албан хаагч бусдыгаа үлгэрлэн манлайлан ажиллах, харилцаа, хандлага, ёс зүйн хувьд мэдрэмжтэй байж бусдыг ойлгон ухаалгаар нөлөөлөх зэрэг дэд сэдвүүдтэй “Удирдлагын ажилтны ёс зүй” сэдэвт сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 4 албан хаагч хамрагдсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дугаар тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан 2023 оны 05 сарын 01-ний өдрөөс 06 сарын 01-ний өдөр хүртэл 1 сарын хугацаатай “Би өгөхгүй, авахгүй” нөлөөллийн аяныг Нийслэлийн Засаг захиргааны I,II,III,IV,Va,Vбв, Нийслэлийн Төр захиргааны цогцолбор байр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв Драгон, Дүнжингарав, Мишээл салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн 12 байршилд зохион байгуулан, нийт 274 албан хаагчдад авлигын хор уршиг, сөрөг нөлөөлөл мөн урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангасан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвөөс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтад 3 албан хаагч амжилттай хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сэдэвт 3 цагийн сургалтыг НЗЗ-ны 5В байрны Иргэний танхимд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан ба сургалтад нийт 141 албан хаагч хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс 2023 оны 06 сарын 23-ны өдөр зохион байгуулсан Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын хууль, эрх зүйн ажилтнуудад зориулсан мэргэжил, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх бүтэн өдрийн сургалтад тус газраас Хууль эрх зүй тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан болон</p> | |
|--|--|--|--|---|--|

| | | | | |
|--|--|--------------------------|---|--|
| | | | | Худалдан авах ажиллагаа, гэрээ хариуцсан ажилтнууд хамрагдсан. |
| Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | | Ажлын байран дах сургалт | 1.1.3. Байгууллага дотооддоо нийт албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх | <p>Зөөгчийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр ширээ засах дүрэм, өдөр тутмын ширээ засалт, захиалгат ширээ засалт, Орос, франц, америк, швед үйлчилгээ үзүүлэх аргууд, үйлчлэх аргууд, шилэн эдлэлийн төрөл ангилал, төмөр эдлэлийн төрөл ангилал, дарс болон оргилуун дарсаар үйлчлэх технологи, зочинтой харьцах, ширээ цэвэрлэх, хоолоор үйлчлэх арга техник зэрэг агуулгын хүрээнд зоогийн газрын үйлчилгээний ажилтнуудыг мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвтэй хамтран бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сэдэвт 3 цагийн сургалтыг НЗЗ-ны 5В байрны Иргэний танхимд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Хүний нөөц хөгжлийн төвийн сургагч багш С.Нарантуяа удирдан зохион байгууллаа. Тус сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Үйлдвэрлэл, үйлчилгээний алба, Инженерийн байгууламж ашиглалт, үйлчилгээний албаны нийт 141 албан хаагч хамрагдсан.</p> <p>Нийслэл Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эвлэлдэн нэгдэх эрх ба Хамтын гэрээ байгуулахын давуу тал, ач холбогдол” сэдвийн хүрээнд нийт 4 цагийн багц сургалтыг зохион байгуулж Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн нийт 32 ажилтан, албан хаагч хамрагдсан.</p> |

| | | | | | |
|---|---|--------|---|---|---|
| | | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас “Ээлтэй орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж байр хариуцсан менежерүүд, угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэн орчин бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ш тэргэнцрийг хүлээн авч НЗЗ-ны байруудад байршуулан үйлчилгээнд нэвтрүүлсэн. | |
| | | 1.2 | Нийт албан хаагчдын тоо | 254 | Тайлант хугацаанд 20 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1238 ажилтан, албан хаагчид хамрагдсан. |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагчид | 162 | 662 |
| | | | Эрэгтэй албан хаагчид | 92 | 542 |
| | | | Удирдах албан тушаалтан | 4 | 34 |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 250 | 1204 гүйцэтгэх, туслах албан тушаалтан |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 2.1 | Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын мэдлэг дээшлүүлэх сургалтад сурах бололцоогоор хангаж дэмжлэг | - | Тайлант хугацаанд: Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн хэл шинжлэлийн магистраар 06 дугаар сард төгсөн, үргэлжлүүлэн Удирдлагын академийн Удирдахуйн Ухааны Их Сургуульд төрийн удирдлагын докторантаар суралцаж байгаа -1, Шихихутаг дээд сургуулийн эрх зүйч бакалавр 05 дугаар сард төгссөн -1, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн “Хүний нөөцийн ажилтныг чадавхжуулах нь” сургалтад хамрагдан гэрчилгээ авсан -1, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаар чадавхжуулах сургалтад хамрагдан гэрчилгээ авсан-5 ажилтан, албан хаагчид байна. ЗГХА, Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн |

| | | | | | | |
|---|-------------------------------------|--------------------|--|---|--|---|
| | | | үзүүлэх | | болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг” олгох гэрчилгээтэй сургалтад 7 ажилтан, албан хаагчид хамрагдсанаас 6 албан хаагч авсан. | |
| | | 2.2. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | - | “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн 15.2.3 дах заалт сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” баримтлан ажилласан. | |
| | | 2.3. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | - | Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн нь 74% хувийг эзлэж байна. | |
| АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ | | | | | | |
| 3 | Цалин хөлс, урамшууллын хэрэгжүүлэх | шагнал, тогтолцоог | 3.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | Төсөвт эзлэх хувь 50% | Тайлант хугацаанд: Ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэл үр дүнг улирлаар дүгнэн ажилтан, албан хаагчдад 946.987.100 төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна. Нийт ажилтан, албан хаагчдын төрийн албанд ажилласан жилийн судалгааг гарган Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно” журмын дагуу ажилласан жилийн нэмэгдэл, илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс зэргийг зохих хууль, журмын дагуу ажилтан, албан хаагчдад нийт 946.987.100 төгрөгийг олгож ажилласан. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ой, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 92 жилийн ой, Санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ойн баярыг тохиолдуулан тус газарт |

| | | | | | |
|---|---|------|---|--|---|
| | | | | <p>тогтвор суурьшилтай, үйлчилгээний салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа 27 ажилтан, албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг боловсруулан холбогдох газарт нь хүргүүлэн ажилласан. Эдгээрт:</p> <p>Монгол Улсын Засгийн газар, салбар яамны шагналаар 4, Монгол Улсын Засгийн газар, сангийн яамны шагналаар 1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн "Хүндэт тэмдэг"-ээр 3, "Хүндэт өргөмжлөл"-өөр 3, "Хүндэт үнэмлэх"-ээр 3, Нийслэлийн Засаг даргын "Нийслэлийн тэргүүний ажилтан" тэмдгээр 2, "Жуух бичиг"-ээр 6, Байгууллагын "Шилдэг ажилтан"-аар 5 ажилтан, албан хаагчид тус тус шагнуулсан байна.</p> | |
| | | 3.2. | Нэгж албан хаагчид олгох, хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | Ажилтан, албан хаагчдад хоол, унааны зардлын зохих хэсгийг олгох | 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажилтан, албан хаагчдад хоолны зардал, унааны хөнгөлөлтөд нийт 1.478.745.900 төгрөгийг олгон ажилласан. |
| 4 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 4.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) | Ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар "Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам"-ын дагуу байгууллагын нийт 272 ажилтан, албан хаагчдыг эрт илрүүлэг, мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-наас 04 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд зохион байгуулж үзлэгт 170 ажилтан, албан хаагчдыг хамруулсан нь нийт албан хаагчдын 62 хувийг эзэлж байна. Байгууллагад шинээр ажилд орсон 40 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ба үзлэгт нийт 1.200.000 төгрөгийг зарцуулсан болно. |
| | | 4.2. | Албан хаагчдын хамрагдалт | | |

| | | | | | | |
|--|--|------|--|--|---|--|
| | | 4.3. | Албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах | Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжин чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох, хамт олны харилцаа хандлагыг эерэг болгох чиглэлээр спортын уралдаан тэцээн зохион байгуулах | <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Цаг гаргая" биеийн тамирын арга хэмжээг гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, ширээний теннис 4 төрөлт тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд нийт ажилтан, албан хаагчдын дунд амжилттай зохион байгуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, "Хай пэймэнт солюшнс" ХХК /Hiray/, Монголын хөнгөн атлетикийн холбоо хамтран зохион байгуулсан "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтэд байгууллагын 16 ажилтан, албан хаагч батламж аван, амжилттай оролцсон.</p> <p>Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 10.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн цахим гүйлт 2023" биеийн тамирын арга хэмжээг Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтан, албан хаагчдын дунд спортын 4 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, ажлын байрны дасгал хөдөлгөөн, дартс) зохион байгуулагдсан тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон 4 төрөлд оролцсон бөгөөд давхардсан тоогоор нийт 48 ажилтан, албан хаагчийг хамруулан идэвхтэй оролцлоо. уулан ажилласан.</p> | |
| | | | | | <p>Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт албан хаагчдад "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй стандартыг мөрдөх нь" сургалтыг НЗЗ-ны 5 дугаар байрны Иргэний танхимд 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр зохион байгуулж нийт 152 албан хаагчид хамрагдсан.</p> | |

| | | | | | | |
|---|--|------|--|---|--|--|
| 5 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 5.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр | Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу буцалтгүй тусламжийг 2 ажилтанд 1.500.000 төгрөг, нас барсны тэтгэмж 11 хүнд 3.300.000 төгрөг, өндөр настны тэтгэвэрт гарсан 6 ажилтанд 109.586.627 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламжийг тус тус олгосон байна. Мөн 1 удаагийн тэтгэмжид 16.998.000 төгрөгийг зарцуулсан ба үүнээс Цагаан сарын баяр болон ахмадын баяраар өндөр настанд 10.650.000 төгрөг зарцуулсан болно. | |
|---|--|------|--|---|--|--|

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
 ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  Б.ЗОЛБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:
 ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
 ХАРИУЦСАН АЖИЛТАН  Д.АМАРЖАРГАЛ